

GOBI
MONGOLIAN CASHMERE



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ
2021.04.24

● АГУУЛГА

- 04 ● Хурлын зар хэлэлцэх асуудлын жагсаалт
- 05 ● Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацаа
- 06 ● Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн хурлын тогтоол
- 08 ● Тооллогын комисс томилох тухай ТУЗ-ийн хурлын тогтоол
- 10 ● Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
- 11 ● Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой материал
- Говь ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны ажлын тайлан, хурлын мэдээлэл
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн хороод
 - 2020 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай
- 17 ● Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл
- 18 ● Санал авах хуудасны загвар

● ХУРЛЫН ЗАР, ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ

● “ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЭРХЭМ ХҮНДЭТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЭ!

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 4 сарын 24-ний өдрийн 11:00 цагт цахим хэлбэрээр шууд дамжуулан зохион байгуулагдах тул хувьцаа эзэмшигч та бүхнийг оролцохыг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2021 оны 4 сарын 1-ний өдөр

● ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Говь ХК-ийн 2020 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
3. 2020 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг танилцуулах
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны ажлын тайланг танилцуулах

Саналын хуудсаар урьдчилан санал өгөх хүмүүс өөрийн харилцдаг брокер, дилерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцан, саналын хуудсаа бөглөж, брокер дилерийн компанидаа өгөх эсвэл **Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК** хаягаар 2021 оны 4 сарын 20-ны өдрөөс өмнө ирүүлнэ үү. Хурлын үеэр цахим санал хураалтад оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 4 сарын 13-ны өдрөөс 4 сарын 20-ны хооронд Үйлдвэрийн дэргэдэх төв дэлгүүр, Галлериа Улаанбаатар салбар дээр бүртгэх тул та бүхэн идэвхтэй оролцоно уу.

Холбоо барих:

Хурал зохион байгуулах комиссын дарга: Ч.Солонго
Утас: 7013-9977

Гишүүд: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: Б.Нарантуяа
Утас: 9411-8277
И-мэйл: boardsecretary@gobi.mn

● ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, УГ БИЧИГ БАРИМТТАЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2021 оны 3 сарын 22-ний өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас (www.mse.mn/mn/company/354), Компанийн цахим хуудас (www.gobi.mn), мөн өөрийн харилцаж буй брокер дилерийн компани дээрээ болон ажлын өдрүүдийн 09:00-17:00 цагийн хооронд Говь ХК-ийн төв байранд байрлах Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын өрөөнд ирж хурлын материалтай танилцаж болно.
2. Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
 - Компанийн санхүүгийн жилийн тайлан
 - Санхүүгийн жилийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт
 - Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн эсэх тухай хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт
 - Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо
 - ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал, бусад зардал
 - Компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан
 - Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 12-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Говь ХК-ийн 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 60, 64, 65 дугаар зүйл, Компанийн дүрмийн 6.2.7.3, 6.2.7.4 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг **2021 оны 4 сарын 24-ний Бямба гарагийн 11:00 цагт** цахимаар шууд дамжуулж хуралдуулсугай. Хурлыг ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа даргалсугай.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 4 сарын 1-ний өдрөөр тогтоож, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид 2021 оны 3 сарын 15-ны өдөр хүргүүлэн, хурлын товыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу 2021 оны 3 сарын 17 болон 4 сарын 1-ний өдрүүдэд олон нийтэд зарласугай.

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2021 оны 3 сарын 22-ний өдрийн дотор брокер дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхээр тогтоосугай.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацааг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 3 дугаар хавсралтаар баталсугай.

“Говь” ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар-17062, Монгол улс
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, Имэйл: info@gobi.mn, Вэб: www.gobi.mn



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 20-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Долоо. Хурлын өдөр хувьцаа эзэмшигчдээс цахимаар санал авахаас гадна компанийн шуудангийн хаягаар болон брокер дилерийн компаниар дамжуулан урьдчилан санал авах сүүлчийн өдрийг 2021 оны 4 сарын 20-ны өдрөөр тогтоож, цахим санал хураалтад оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 4 сарын 13-ны өдрөөс 4 сарын 20-ны хооронд бүртгэж, санал авах хуудасны агуулга, загварыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

Найм. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг 5 дугаар хавсралтаар баталсугай.

Ес. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 6 дугаар хавсралтаар баталсугай.

Арав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, хурлыг зохион байгуулах, хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж ажиллахыг комиссын дарга Ч.Солонго-д даалгасугай.

Комиссын дарга:	Тэргүүн дэд захирал	Ч.Солонго
Гишүүд:	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Б.Нарантуяа
	Мэдээлэл технологи хариуцсан захирал	Б.Эрдэнэ

ТУЗ-ийн ДАРГА:



ТУЗ-ийн ГИШҮҮД:

Д.ГЭРЭЛМАА

Ч.БААТРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ

А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

“Говь” ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар-17062, Монгол улс
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, Имэйл: info@gobi.mn, Вэб: www.gobi.mn

ТООЛЛОГЫН КОМИСС ТОМИЛОХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 08 сарын 12-ны өдөр

Дугаар 129

Улаанбаатар хот

Тооллогын комисс томилох тухай

Говь ХК-ийн 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдахтай холбогдон Тооллогын комиссыг томилох тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 67.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай:

Комиссын дарга:	Н.Сайнзул – Дотоод аудитын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Цэцэгбадам – Санхүү бүртгэлийн албаны дарга
Гишүүд:	Т.Мөнхзул – Ахлах аудитор
	Б.Уянга – Хөдөлмөрийн харилцаа хариуцсан албаны дарга

Хоёр. Тооллогын комисс (Н.Сайнзул)-д даалгах нь:

1. Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;
2. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох;
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултад тайлбар өгөх;
4. Санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
5. Хувьцаа эзэмшигчид цахим санал хураалтад оролцох бүртгэлийг хийх;
6. Саналын хуудсыг хайрцгаар мөн цахим хэлбэрээр авах;
7. Саналыг тоолж, энэ тухай тэмдэглэл хөтлөх;
8. Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;

“Говь” ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар-17062, Монгол улс
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, Имэйл: info@gobi.mn, Вэб: www.gobi.mn



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.11 оны 03 сарын 12-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

ТУЗ-ийн ДАРГА:

ТУЗ-ийн ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

Д.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ

А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

● ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

1. Хурлын ирцийг хурлын даргад мэдэгдэх
/Тооллогын комиссын дарга Н.Сайнзул/ 3 минут
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах
/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/ 3 минут
3. Тооллогын комиссыг томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа/ 3 минут
4. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина:
 - 4.1. Компанийн 2020 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах
/Тэргүүн дэд захирал Ч.Солонго/ 15 минут
 - 4.2. ТУЗ-өөс компанийн 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/ 10 минут
 - 4.3. 2020 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа/ 3 минут
 - 4.4. ТУЗ-ийн 2020 оны ажлын тайланг танилцуулах
/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/ 10 минут
5. Урьдчилан бүртгэж авсан асуултад хариулт өгөх
/Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан/ 10 минут
6. Санал авах 15 минут
7. Цайны завсарлага 15 минут
8. Санал хураалтын дүнг нэгтгэн, тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах 5 минут
9. Хурлаас гарах тогтоолын төсөлд Тооллогын комиссын санал хураалтын дүнг тусган танилцуулж, тогтоолыг батлуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа/ 3 минут

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг

Жич: Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

● ГОВЬ ХК-ИЙН -2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Говь ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2020 оны зорилтуудын талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Сайн засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдлөг болгож, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан 2020 оны бизнес төлөвлөгөө нь компанийн нийт борлуулалтын орлогыг өмнөх оноос 27% өсгөх, нийт ажилтны тоог тогтвортой түвшинд байлгаж, шинээр Канад, Австрали, Япон, Орос, Энэтхэг болон Казакстаны зах зээлд нэвтэрч нийт 200 мянган эцсийн бүтээгдэхүүнийг хилийн чанд дахь өөрийн дэлгүүр болон цахим борлуулалтын сувгаар борлуулах, Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO45001:2018 болон Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO14001:2015 стандартын баталгаажуулалтуудыг авах, олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлыг дахин идэвхжүүлэхэд тус тус чиглэсэн билээ. Говь ХК 2020 онд 117,1 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж, бизнес төлөвлөгөөний биелэлт 44 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Гадаад борлуулалт 2020 онд 36 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 30.8 хувь, дотоод борлуулалт 49.5 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 42.2 хувь, онлайн борлуулалт 31.6 тэр бум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 27 хувьд хүрчээ.

Мөн тайлант жилд 655 тонн түүхий эд бэлтгэж, нийт 916 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 243 сая төгрөг буюу 26%-ийг барилга байгууламжийн бүтээн байгуулалт, 273 сая төгрөг буюу 30%-ийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 261 сая төгрөг буюу 29%-ийг бусад хөрөнгө оруулалтад зориулсан байна. Харин биет бус хөрөнгүүд болох барааны тэмдэгт, программ хангамжид 138 сая төгрөг буюу 15%-ийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Иймд Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2020 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2020 онд нийт 7 ээлжит болон 15 ээлжит бус хурал зохион байгуулж, 27 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилт дээр анхаарч ажиллав. Мөн ТУЗ-ийн дэргэдэх хороод ажлын тайлангаа тогтмол танилцуулж ажилласан бөгөөд хороодын хурал товлосон хугацаандаа амжилттай зохион байгуулагдаж, гишүүд идэвх санаачилгатай ажиллалаа. Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой ТУЗ-ийн хурал, хороодын хурлыг ихэвчлэн зайнаас зохион байгууллаа.

Агуулга	Баталсан тогтоол	Он сар өдөр
Үйл ажиллагаа өргөжүүлэх, хөрөнгө оруулалт	Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	2020.01.10
	Гоёо ХХК-тай холбогдуулан гаргасан шийдвэрийг дэмжин, баталгаажуулах	2020.03.25
Компанийн дотоод үйл ажиллагаа	Компанийн 2020 оны бизнес төлөвлөгөө, зорилтыг батлах	2020.01.22
	Ногдол ашиг хуваарилахгүй тухай	2020.02.14
	2020 онд сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийгдэх хэлцэлд зөвшөөрөл олгох	2020.02.14
	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах	2020.03.14
	Тооллогын комисс томилох	2020.03.14
	ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах	2020.05.14
	Байгууллагын нэр дээрх бизнес зээлийн картуудын лимитийн хугацааг сунгуулах	2020.05.27
	Эрсдэлийн удирдлагын бодлого шинэчлэн батлах тухай	2020.06.22
Санхүүжилт	Гоёо ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг татан буулгах	2020.10.29
	Худалдаа Хөгжлийн банкнаас зээл авахыг зөвшөөрөх	2020.02.10
	Зээлийн багц гэрээний хугацаа сунгах, хөрөнгө үргэлжлүүлэн барьцаалах	2020.04.15
	Худалдаа Хөгжлийн банкнаас зээл авахыг зөвшөөрөх	2020.04.17
	ТУЗ-ийн 2019.12.04-ний 30 дугаар тогтоолд нэмэлт заалт оруулах	2020.05.19
	Хөрөнгө үргэлжлүүлэн барьцаалах	2020.05.21
	Зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, хугацаа сунгах, хөрөнгө үргэлжлүүлэн барьцаалах	2020.05.25
	Европын Сэргээн Босголт Хөгжлийн банкны зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах	2020.06.04
	Зээлийн нэмэлт гэрээ байгуулах	2020.08.10
	Хөрөнгө сольж барьцаалах	2020.08.13
	Зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	2020.09.17
	Хас банкнаас зээл авах зөвшөөрөх	2020.10.05
	Зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, хамтран зээлдэгчээр орох	2020.10.19
Хүний нөөц	Ажилд томилох тухай ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга	2020.02.14
	Гоёо ХХК-ийн Гүйцэтгэх захирлыг үүрэгт ажлаас чөлөөлөх	2020.04.21
	Гоёо ХХК-ийн Гүйцэтгэх захирлыг томилох	2020.04.21
	ТУЗ-ийн даргыг томилох	2020.05.14

● ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

№	Огноо	Ээлжит хурал	Ирц	Ээлжит бус хурал	Ирц	Нийт баталсан тогтоолын тоо
1	2020.01.10			*	100%	1
2	2020.01.22	*	100%			1
3	2020.02.10			*	100%	1
4	2020.02.14	*	100%			3
5	2020.03.14	*	100%			2
6	2020.03.25			*	100%	1
7	2020.04.13	*	100%			1
8	2020.04.15			*	100%	1
9	2020.04.21			*	100%	2
10	2020.05.14			*	100%	2
11	2020.05.19			*	100%	1
12	2020.05.21			*	100%	1
13	2020.05.25			*	100%	1
14	2020.05.27			*	100%	1
15	2020.06.04			*	100%	1
16	2020.06.22	*	100%			1
17	2020.08.10			*	100%	1
18	2020.08.13	*	100%			1
19	2020.09.17			*	100%	1
20	2020.10.05			*	100%	1
21	2020.10.19			*	100%	1
22	2020.10.29	*	100%			1
Нийт		7		15		27

Тайлбар:

Япон улсад байдаг хоёр гишүүдэд ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурлын мэдээллийг цах тухай бүрд хүргэж, саналыг цахим шуудангаар авч, тогтмол харилцаатай ажилладаг.

● ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

ЭРСДЭЛ АУДИТЫН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдалд хяналт тавих, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавин чиглүүлэх, хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

БҮРЭЛДЭХҮҮН

Эрсдэл, аудитын хорооны дарга:
ТУЗ-ийн хараат бус гишүүн **Б.Нандин-Эрдэнэ**

Гишүүд:
ТУЗ-ийн хараат бус гишүүн **А.Жаргалмаа**
ТУЗ-ийн ердийн гишүүн **Д.Хулан**

2020 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Эрсдэл аудитын хороо нь 2020 онд 4 удаа ээлжит хурал зохион байгуулж, 17 асуудлыг хэлэлцсэн. Хорооны чиг үүргийн хүрээнд 11 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг холбогдох албан тушаалтан, албадуудад өгч, хяналт тавьж ажиллав. Эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд санхүүгийн тайлан, НББ-ийн талаар хараат бус аудиторын дүгнэлт зөвлөмжтэй танилцаж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Эрсдэлийн удирдлагын баг болон дотоод аудитын хэлтсийн ажлын гүйцэтгэл, хагас жилийн болон жилийн ажлын тайлантай цаг тухай бүрд танилцаж удирдамжаар хангасан. Түүнчлэн хөндлөнгийн аудиторын сонгон шалгаруулалтад хорооны гишүүд санал өгч оролцож сонгон шалгаруулав. Мөн эрсдэлийн удирдлагын бодлогыг шинэчлэн баталж дотоод аудитын хэлтсийн 2020 оны үйл ажиллагаа болон цалингийн төсвийг батлав.

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

БҮРЭЛДЭХҮҮН

Нэр дэвшүүлэх хорооны дарга:
ТУЗ-ийн хараат бус гишүүн **М.Баяр**

Гишүүд:
ТУЗ-ийн хараат бус гишүүн **Д.Гэрэлмаа**
ТУЗ-ийн ердийн гишүүн **Ц.Баатарсайхан**

Нэр дэвшүүлэх хороо нь 2020 онд 2 удаа ээлжит хурал зохион байгуулж, 6 асуудлыг хэлэлцэв. Мөн хорооны чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 8 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч ажиллалаа.

Энэ онд тус хороо нь менежмент багийн жилийн болон хагас жилийн тайлантай танилцаж, тус тайланд гүйцэтгэх захирлаас өгсөн дүгнэлттэй танилцав. Менежмент багийн жилийн тайлан болон гүйцэтгэлд үндэслэн хамт олноо манлайлан удирдаж, амжилттай ажилласан удирдлагуудыг ТУЗ-ийн нэрэмжит шагналд нэр дэвшүүлэн, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шагнав. 2020 оны ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийж, үр дүнд нь үндэслэн ТУЗ болон хороодын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд цаашид гүйцэтгэх ажлуудыг хэлэлцсэн бөгөөд Компанийн засаглалын өөрийн үнэлгээг гүйцэтгэж Монголын хөрөнгийн бирж болон компанийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд тайлагнан ажиллалаа.

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг томъёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

БҮРЭЛДЭХҮҮН

Цалин, урамшууллын хорооны дарга:
ТУЗ-ийн хараат бус гишүүн **Д.Гэрэлмаа**

Гишүүд:
ТУЗ-ийн хараат бус гишүүн **Такэши Камбэ**
ТУЗ-ийн ердийн гишүүн **Ж.Оюунчимэг**

2020 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Цалин урамшууллын хороо нь 2020 онд 2 удаа ээлжит хурал зохион байгуулж, 7 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Мөн хорооны чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 3 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч чиглүүлэн ажиллав.

Энэ онд тус хороо нь компанийн хэмжээнд цалин урамшуулал, нийгмийн халамжийн хүрээнд хийгдсэн ажлын тайлан, компанийн соёлын болон сэтгэл ханамжийн судалгааны ажлын үр дүнтэй танилцан санал зөвлөмжийг өгч ажиллалаа.

Мөн хорооны чиг үүргийнхээ дагуу өнгөрсөн оны цалин урамшууллын гүйцэтгэлд хяналт тавьж, ирэх жилийн цалин урамшууллын төсвийг баталлаа.

● НОГДОЛ АШИГ

Манай компани нь дотоодын зах зээлд байр сууриа хадгалах, улмаар зах зээлд эзлэх хувиа өсгөх, гадаад зах зээлээ тэлэхийн тулд техник, технологио шинэчлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр чармайн ажиллахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгө оруулалтын өгөөжийг тасралтгүй өсгөж, ногдол ашиг тогтмол тараах бодлогыг баримталдаг.

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн №05 тоот тогтоолын дагуу 2020 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

● ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСӨЛ

Төсөл

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 24

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.9.10 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2021 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Хавсралт 1 ёсоор баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

● САНАЛ АВАХ ХУУДАСНЫ ЗАГВАР



“ГОВЬ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

“Говь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын өдөр: 2021 оны 04 сарын 24-ний өдөр

Эхлэх цаг: 11:00 цаг

Хурлын хэлбэр: Цахимаар хуралдана.

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Регистрийн дугаар

Эзэмшиж буй хувьцааны тоо төрөл **энгийн**

№	Шийдвэр гаргаж, батлах асуудлын нэр	Хурлаас гаргах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах	ТУЗ-ийн дүгнэлт: Өөрсдийн нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглан ажилласан				

2021 оны ... -р сарын ... -ны өдөр

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг

Тооллогын комисс бөглөх хэсэг:

Хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн дугаар:

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм ☐ Үгүй ☐

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан:

.....

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Санал авах хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө.

- Саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож, (✓) тэмдэг тавина.
Жишээ нь: зөвшөөрсөн бол “Зөвшөөрсөн” гэсэн нүдэнд (✓), татгалзсан бол “Татгалзсан” гэсэн нүдэнд (✓), түдгэлзсэн бол Түдгэлзсэн гэсэн нүдэнд (✓) тэмдэг тавина.
- Хэрэв та хэлэлцэж буй асуудлын шийдвэрийн төслийг татгалзсан саналтай байгаа бол “Таны өгөх санал” гэсэн нүдэнд уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх саналтай байгаагаа бичнэ.
- Засварласан, балласан, (✓)-ээс өөр тэмдэглэгээ хэрэглэсэн болон аль нэг саналыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.

2. Хэрэв та саналын хуудсаар урьдчилан саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, өөрийн харилцдаг брокер дилерийн компанидаа хүргэх эсвэл Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, “Говь” ХК хаягаар 2021 оны 04 сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

3. Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгөн, нотариатаар баталгаажуулсан байна.

GOBI
MONGOLIAN CASHMERE

“ГОВЬ” ХК, ҮЙЛДВЭРИЙН ГУДАМЖ, 3-Р ХОРОО, ХАН-УУЛ ДҮҮРЭГ,
УЛААНБААТАР-17062, МОНГОЛ УЛС, Ш/Х 36/434
УТАС: +976 7013-9977, ФАКС: +976 7014-3081
И-МЭЙЛ: INFO@GOBI.MN